

“АЧИТ АЛХАБЫ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 07

Өлгий сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 2026 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 10⁰⁰ цагт “Мирас” ЗБН-ийн байранд хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэхээр баталсугай.
 1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 2. 2025 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танхлцуулах;
 3. ТУЗ-ийн гишүүнийг шинээр сонгох;
 4. Компанийн 2026 оны төлөвлөгөө, төсөв батлах
3. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөр тогтоосугай,
4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг 2026 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр өдөр тутамын сониноор зарлах, хурлын зар мэдээг зарласан өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр анх зарласан хэлбэрийн дагуу дахин зарлахыг хурал зохион байгуулах комисс К.Ахжархын-д даалгасугай,
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсаралтаар баталсугай,
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баритын жагсаалтыг хоёрдугаар хавсаралтаар баталсугай,
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралаар баталсугай,
8. Саналын хуудас хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөр тасалбар болгосугай,
9. Компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга К.Ахжархыныг томилсугай,
10. Компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын комиссын даргаар К.Ахжархын, гишүүдээр Х.Халамхан, Х.Калимат нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА К.АХЖАРХЫН

